



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

**2023 оны 6
дугаар сар**

**АУДИТЫН СЭДЭВ: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	4
Графикийн товъёг.....	5
Хавсралтын товъёг:	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
А.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаагүй байна	8
А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох зарим хууль тогтоомж, эрх зүйн акттай нийцээгүй байна	8
А1.2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн бодлогын баримт бичгүүдийг баталж мөрдөж байгаа боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй байна.	9
А1.3. Агнуурын болон ойн менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн батлаагүй байна	14
А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнээгүй байна	19
А.2.1 БОАЖ-ын сайдын Баян-Өлгий аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй, хүрэх түвшин хангагдаагүй байхад биелэлтийг өндөр үнэлгээгээр дүгнэсэн байна	19
А2.2.Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнээгүй байна.	21
Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна.....	23
Б.1. Төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна	23
Б1.1. Байгалийн нөөцийг ашиглах төрөл, дээд хэмжээг зохих журмын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна	23
Б1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журамд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна	25
Б1.3.Байгалийн нөөцийн ус, рашаан ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгоогүй байна. ..	26
Б.1.4.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөлт, ногдуулалт хангалтгүй байна	28
Б.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжээгүй байна	35
Б2.1. Төлбөрийн орлогыг 2021-2022 онд хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж батлуулаагүй байна	35
Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй байна	39
В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авч ажиллаагүй байна	42
В.1. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчгүй, хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв байдал хангагдаагүй байна.	42
В.1.1 Мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал 2022 оноос хангагдсан байна.	42
В.1.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо үр дүнгүй байна.	45
В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнээгүй байна	46
В.2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын 2018-2021 оны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийсэн байна	46
В.2.2 Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагаас 2021-2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгдээгүй байна	47
ДҮГНЭЛТ:	51
САНАЛ:	52
ЗӨВЛӨМЖ:.....	53

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
ГАА	Говь-Алтай аймаг
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖЯ	Байгаль орчин аялал, жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин аялал, жуулчлалын газар
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээний дотоод аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтйн хэлтэс
АБН	Агнуурын бүс нутаг
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
БИОФИН	Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга
БОУХБ	Байгаль орчны Улсын хяналтын байцаагч

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	11
Хүснэгт 2	Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	11
Хүснэгт 3	Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	11-12
Хүснэгт 4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилт	12
Хүснэгт 5	Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2021-2023 оны төлөвлөгөө	12
Хүснэгт 6	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилт	14
Хүснэгт 7	Аймгийн 2021-2023 оны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	15
Хүснэгт 8	Сумууын байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээ	22
Хүснэгт 9	Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг дарга нарын байгуулсан гүйцэтгэлийн гэрээний үнэлгээ	22-23
Хүснэгт 10	Ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний тоо	24
Хүснэгт 11	2021-2023 онуудад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, төвлөрүүлэлтийн нөөцийн төрөл	29
Хүснэгт 12	Аймгийн ус ашигласны төлбөрийн орлогын 2021-2023 оны төлөвлөгөө	30
Хүснэгт 13	Аймгийн 2021-2023 оны зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй ус ашиглагчийн мэдээлэл	30
Хүснэгт 14	Аймгийн хэмжээнд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны орлогын төлөвлөгөө	32
Хүснэгт 15	Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн 2021-2023 оны орлогын төлөвлөгөө	33
Хүснэгт 16	Аймгийн ИТХ-аас баталсан газрын төлбөрийн төлөвлөгөө, аймгийн ГХХБГ-ын цахим системд бүртгэсэн ногдуулалт зөрүү	34
Хүснэгт 17	“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хувь хэмжээг тогтоосон байдал	35-36
Хүснэгт 18	Байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж баталсныг 2021-2023 онуудаар харуулав.	36
Хүснэгт 19	Мэдээллийн санд зарцуулах хөрөнгийн төлөвлөлт/ сумуудаар/	37
Хүснэгт 20	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлтийг /БНАТ-2-А маягт/ оруулсан сумуудын мэдээллийн сангийн үзүүлэлт	37-38
Хүснэгт 21	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болон тусгаадаагүй арга хэмжээн зарцуулах төлөвлөгөө / аймгийн хэмжээгээр/	38
Хүснэгт 22	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах 2022 оны төсвийн хуваар	40
Хүснэгт 23	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, хуулийн хэрэгжилт	41
Хүснэгт 24	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2023 оны зарцуулалт	42
		36

Графикийн товьёг

График №01	2021-2023 онуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, төвлөрүүлсэн байдал	29
График №02	Аймгийн хэмжээний 2021-2023 оны газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн, ноогдуулсан, төлсөн байдал	34
График №03	Аймгийн хэмжээний 2021-2023 оны газрын төлбөрийн ноогдуулсан болон төлсөн байдал	34
График №04	Төлөвлөгөө талыг оруулах заавар, маягт	43
График №05	Гүйцэтгэл талыг гаргах заавар, маягт	44
График №06	Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн мэдээ	46
График №07	Байгаль орчны газраас хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэл	47

Хавсралтын товьёг:

Хавсралт №01	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны төлөвлөгөө, төвлөрүүлэлтийн судалгаа	49
Хавсралт №2	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэсгийн судалгаа	49-50

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай А/04 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэв.Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийэ, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Х.Манаргүл, Б.Үүрийнтуяа, Х.Еркебулан, С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2023 оны 5 дугаар сарын 04-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн дотор Говь-Алтай аймгийн ТАГ-т, 06 дүгээр сарын 22-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Сумуудаас аудитад шаардлагатай баримт материал, судалгаа мэдээллийг хугацаандаа бүрэн ирүүлээгүй байсан нь аудитыг хэрэгжүүлэх хугацаа алдах, аудитын тайлан хугацаа хоцрох эрсдэлийг бий болгосон.

А.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаагүй байна

А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна

А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох зарим хууль тогтоомж, эрх зүйн акттай нийцээгүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад холбогдох харилцааг тусгасан зарим хууль, тогтоомж, бусад эрх зүйн акттай нийцээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.” гэсний дагуу ЗГ-ын 2022 оны 02 тоот тогтоолоор баталсан журмын 2.2-т. “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалт нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-т “батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.” гэж заасан нь нийцээгүй ба газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг бусад нөөцийн адил энэ хуулиар зохицуулахаар өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Орон нутгийн тусгай хамгаалалтад авагдсан газруудын менежментийн төлөвлөгөө аймгийн хэмжээнд батлагдаагүй байгаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6¹ дугаар зүйлийн 5 дахь заалтын хэрэгжилт хангагдахгүй байгаатай холбоотой тул заалтыг “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэлэлцүүлж батлах” гэж тодорхой тусгаж өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-аар жил бүр чоно, үнэг агнах тоо, төлбөрийн хэмжээг тогтоож өгч байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлнө”, 22.1.3-т “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Аймгийн тухайн жилийн төсөв бүрдүүлэлтээс хамаараад БНАТ-ын зарцуулах төлбөрийг хамгийн доод хязгаараар баталдаг тул төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг нэмэгдүүлснээр тухайн жилийн байгалийн нөөцийг хамгаалах төсөв нэмэгдэх тул Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль

орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэсэнд өөрчлөлт оруулж усны болон ан, амьтны нөөцийн төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг тус бүр 10 хувиар нэмэгдүүлэх боломж бий.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 10-т “Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого болон гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна.” гэсэн нь хууль бус ашиглалтын улмаас олсон орлогыг тухайн аймагт төвлөрүүлж эргээд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх тул тухайн аймаг, сумын Байгаль хамгаалах санд төвлөрүүлэх талаар хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 11-д “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлнэ.” гэж заасан ба орон нутагт байгаль орны эсрэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх ажиллагаанд шаардлагатай зардал гаргах төсөв байдаггүй тул “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал зэрэг байгаль орчинд учирсан хохирлыг тооцуулах зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр орон нутгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлнэ.” гэж өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хилийн бүсэд байрлаж байгаа заставууд нь улсын төсвөөс санхүүжилт авдаг тул Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд Хилийн бүсэд байрлаж байгаа заставуудын хилийн бүс, зурвасын ойгоос бэлтгэсэн түлээний модны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх талаар заалт оруулах нь зүйтэй байна.

А1.2. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн бодлогын баримт бичгүүдийг баталж мөрдөж байгаа боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий урт, дунд, богино хугацааны төрөлтэй байна гэж заажээ.

“Баян-Өлгий аймгийн хөгжлийн дунд хугацааны стратеги, “Хөгжлийн зураглал-2030”, “Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой

¹6.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна:

6.1.1.урт хугацааны;

6.1.2.дунд хугацааны;

6.1.3.богино хугацааны

дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг урт, дунд хугацааны үндэсний бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байна.

Аймгийн дунд хугацааны хөгжлийн баримт бичиг болох “Хөгжлийн зураглал-2030”-д байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, тогтвортой байдлыг хангах үүднээс ногоон хөгжлийн бодлогыг тэргүүлэх чиглэлийн нэг болгон оруулж, ногоон хөгжлийн зорилтот түвшнийг бүрэн хангах стратегийн зорилгыг дэвшүүлсэн байна.

Ногоон хөгжлийн зорилтот түвшнийг бүрэн хангах стратеги зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд :

- Байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- Байгалийн баялгийн үр өгөөжийг зохистой ашиглана.
- Ногоон байгууламж, ойн сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

“Хөгжлийн зураглал-2030”-д дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх 4 арга зам түүний хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолоор баталсан аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үндсэн баримт бичиг болох 2021-2030 он хүртэлх аймгийн хөгжлийн дунд хугацааны стратеги “Хөгжлийн зураглал-2030”-д тусгагдсан зорилго, зорилтуудтай аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд уялдсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5², 6.5.4³ дахь заалтын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлигийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2021 оны ээлжит VI дугаар хуралдааны 48 дугаар тогтоолоор “Ногоон Өлгий дэд хөтөлбөр”-ийг 2022-2030 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

“Ногоон Өлгий дэд хөтөлбөр” нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд үнэт үүлдрийн модоор ойжуулж, олон зорилтот ногоон байгууламж, меллиораци, арга ойн аж ахуй хөгжүүлэн Баян-Өлгий аймгийн хэмжээнд 20.0 сая мод тарьж, байгалийн унаган төрхийг сэргээн, агаарын чанарыг сайжруулж, иргэд аюулгүй, тав тухтай, таатай орчинд амьдрах орчин, нөхцөл бүрдүүлэх” үндсэн зорилготой ба 2022, 2023 онуудад 5 зорилтын хүрээнд улс, орон нутаг, гадаадын зээл тусламж болон олон нийтийн оролцооны бүлгийн 4,305.7 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийг Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 86 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит II дугаар хуралдааны 13 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7⁴, -д заасны дагуу баталсан Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд

^{6.5.} Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна

^{6.5.4.} байгаль орчны зорилтот хөтөлбөр

^{6.7.} Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан Ногоон хөгжлийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс өөрийн аймгийн онцлогт нийцүүлэн 1 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ, үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2⁵, 6.7.2.а⁶-д заасан шаардлагуудыг хангасан байна.

Хүснэгт: №1

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой		Үүнээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	
	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ
Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1	9	1	4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 2021 онд 87 хувь, 2022 онд 91 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Хүснэгт: №2

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилт						2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний тоо
	2021 он			2022 он			
	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	
Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	9	8	87%	9	8	91%	10

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан аймгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Баян-Өлгий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Байгалийн нөөц, орчны бохирдлыг бууруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, хүрээлэн буй орчныг сайжруулах” зорилгын хүрээнд 5 зорилт дэвшүүлж, 15 арга хэмжээг тусгаж төлөвлөсөн ба эдгээр арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрт улс, орон нутгийн төсвөөс 126.0 сая төгрөг төлөвлөсөн байна. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 4 зорилт дэвшүүлж, 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт: №3

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой	Үүнээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой
-----------------------------	--	--

⁶ 6.7.2.а.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээс тухайн аймаг, нийслэл, хотод хамаарахыг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх

	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт ийн эх үүсвэр	Мөнгөн дүн /сая төгрөг/	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт ийн эх үүсвэр	Мөнгөн дүн /сая төгрөг/
Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	6	15	Улс, орон нутгийн төсөв	126.0	4	10	Улс, орон нутгийн төсөв	124.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг 2021 онд 92.8 хувь, 2022 онд 90.6 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Хүснэгт: №4

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилт						2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний тоо
	2021 он			2022 он			
	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	
Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5	5	92.8	6	5	90.6	5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Баян-Өлгий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.3-т “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна” гэсний дагуу 6.8.3а⁷-6.8.3г-д заасан шаардлагуудыг хангасан байна.

Байгалийн нөөц, орчны бохирдлыг бууруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, хүрээлэн буй орчныг сайжруулах зорилтын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний эх үүсвэр, хөрөнгийн хэмжээ үндэслэлгүй төлөвлөгдсөн буюу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4⁸-т заасан шаардлагыг хангасан боловч санхүүжилтийн хэмжээг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

Байгалийн нөөц, орчны бохирдлыг бууруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, хүрээлэн буй орчныг сайжруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 15 арга, хэмжээнд 2021-2024 онд зарцуулах нийт төсөв 126.0 сая төгрөг, үүнээс 2021 онд 1.5 сая, 2022 онд 71.5 сая, 2023 онд 51.5 сая, 2024 онд 1.5 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөсөн нь үндэслэлгүй байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны

6.8.3.а.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг сонгон боловсруулсан байх

6.8.3.б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх6.8.3.в.тухайн орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх

6.8.3.г.бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, харилцан уялдаатай хөгжих боломжийг хангасан байх /.

6.8.4. /6.8.4.а.зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх ,

6.8.4.б.үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тооцож боловсруулсан байх /.

төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁹, 13.2¹⁰, 18 дугаар зүйлийн 18.1¹¹-дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө юм.

Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2021, 2022, 2023 оны төлөвлөгөөнд аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээтэй уялдуулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөж ажилласан байна.

Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ, 2022 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ, 2023 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хэмжээг авч үзвэл 2021 онд 64.0 сая төгрөг, 2022 онд 110.0 сая төгрөг төлөвлөсөн байна. 2023 онд 520.0 сая төгрөг төлөвлөж өмнөх онтой харьцуулахад 3.7 дахин нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Энэ нь БОАЖЯ-аас 2021 онд “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль” болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2018-2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, дотоод аудитын дүнгээр аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын дарга нарт хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж эхэлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт: №5

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой				Үүнээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой			
	Дэвшү үлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн /сая төгрөг/	Дэвшү үлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн /сая төгрөг/
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө	1	8	Улс, орон нутгийн төсөв	64.0	1	3	Улс, орон нутгийн төсөв	64.0
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	1	4	Улс, орон нутгийн төсөв	240.0	1	3	Улс, орон нутгийн төсөв	110.0
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	1	3	Улс, орон нутгийн төсөв	770.0	1	6	Улс, орон нутгийн төсөв	520.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

⁹ 13.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

¹⁰ 13.2. Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ: 13.2.1. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.2. ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.3. ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;

¹¹ 18.1. Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн 1 зорилт 8 арга хэмжээний хэрэгжилт 98 хувийн, 2022 онд хэрэгжүүлэх 4 арга хэмжээний хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт: №6

Бодлогын баримт бичгийн нэр	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилт						2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний тоо
	2021 он			2022 он			
	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн тоо	Хэрэгжилтийн хувь	
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө	8	8	98%				
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө				4	4	95%	
Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө							3

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

А1.3. Агнуурын болон ойн менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн батлаагүй байна

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхээр заажээ.

Аймаг, сумын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдуулан холбогдох хуулиудад зааснаар аймгийн болон ой бүхий сумуудын, ойн нөхөрлөлийн, агнуурын нөөц бүхий аймгийн, сумуудын ан агнуурын бүс нутгийн, улсын тусгай хамгаалалттай газрын болон орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зэрэг менежментийн төлөвлөгөө, аймаг, сумуудын 2021-2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг баталж хэрэгжүүлэх эрх, үүрэгтэй.

Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдсон менежментийн нэгдсэн төлөвлөгөө байхгүй байна.

Аймгийн хэмжээнд нийт 97 менежментийн төлөвлөгөө баталж хэрэгжүүлэхээс 2021-2023 онд 39 менежментийн төлөвлөгөөтэй байсан ба хэрэгжилт 40.2 хувьтай байна.

Хүснэгт №7

Холбогдох хууль	Нэр	Тоо	Менежментийн төлөвлөгөөтэй эсэх
Ойн тухай хууль	Ойн нөөц бүхий аймаг-Баян-Өлгий	1	1
	Ойн нөөц бүхий сумууд	10	10
	Ойн нөөц бүхий сумын ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл	32	0
Амьтны тухай хууль	Агнуурын нөөц бүхий аймаг-Баян-Өлгий	1	1
	Сумуудын ан агнуурын бүс нутаг	26	26
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль	МАНУТХГЗ	1	1
	Чигэртэйн голын ай савын Байгалийн Цогцолборт Газрын менежментийн төлөвлөгөө	1	0
	Орон нутгийн хамгаалалттай газар нутаг	25	0
Дүн		97	39

Эх сурвалж: Аудитын судалгаа

Монгол Улсын тусгай хамгаалалттай Чигэртэйн голын ай савын Байгалийн Цогцолборт газар, Ойн нөөц бүхий 10 сумын ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч 32 нөхөрлөл, Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны 25 бүс менежментийн төлөвлөгөөгүй байна.

Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг Агнуур судлалын нийгэмлэг ТББ-аар 2018 онд хийлгэж аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 18-ны 21 дүгээр тогтоолоор дэмжиж, БОАЖЯ-нд хүргүүлсэн ба яамнаас 2019 онд баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит V дугаар хуралдааны 186 дугаар тогтоолоор аймгийн ан агнуурын 2018-2022 оны менежментийн төлөвлөгөөний хугацааг өмнөх тогтоолоор буруу баталсан хугацааг 2019-2023 онд хэрэгжүүлэхээр дэмжих шийдвэр гаргаж, тогтоолдоо өөрчлөлт оруулсан байна.

Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2023 оны байдлаар хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлж шинэчлэн боловсруулж байгаа юм байна.

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 5.3.2-т “агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан байна.

Тус аймгийн 12 сумын нутагт Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9¹²-д заасан агнуурын 26 бүс байгаагаас Алтанцөгц, Баяннуур, Булган, Буянт сумууд тус бүр агнуурын 1, Алтай, Бугат, Дэлүүн, Сагсай, Цэнгэл сумууд тус бүр 2, Улаанхус сум 3, Толбо сум 4, Ногооннуур сум 6 агнуурын бүс нутагтай байна.

¹² 4.1.9. "агнуурын бүс нутаг" гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг.

Агнуурын бүс нутагт Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23¹³-д заасны дагуу ангийн аж ахуйн эрхэлж байгаа мэргэжлийн байгууллагууд ан агнуурын менежментийн төлөвлөгөөгөө БОАЖЯ-аар батлуулж ажилласан байна.

Ангийн аж ахуйнуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дунджаар 4-5 жил, хэрэгжүүлэх арга хэмжээний тоо 12-78, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн эх үүсвэр санхүүжилт 16.0-70.5 сая төгрөг байна.

Агнуурийн бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд 2021 онд 428, 2022 онд 572, 2023 онд 460, нийт 1460 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Агнуурийн бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд 2021, 2022 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө хэрэгжих боломжгүй үндэслэлгүй төлөвлөгдсөн байна.

Алтай сумын "Халуун бардам" АБН, Бугат сумын "Тошинт хатуугийн гол" АБН-үүдийн менежментийн төлөвлөгөө хэрэгжих хугацаа 2021 онд, Сагсай сумын "Бөхөн" АБН, Бугат сумын "Төмөрт" АБН-ийн, Булган сумын "Улаагчин" АБН, Ногооннуур сумын "Бураат" АБН, Ногооннуур сумын "Модон овоо" АБН, Улаанхус сумын "Мянган уул" АБН-ийн менежментийн төлөвлөгөөний хугацаа 2022 онд дууссан байна.

АБН-уудын менежментийн төлөвлөгөөг 2023 оны байдлаар шинэчилж батлаагүй байна. 2023 онд 6 агнуурийн бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дуусаж байгаа юм байна.

Сумуудын АБН-ийн менежмент хариуцагч аж ахуйн нэгж байгууллагууд тухайн оны ангийн аж ахуйн үйл ажиллагааны тайлангаа БОАЖГ-т ирүүлсэн байна.

Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 2021 онд 13, 2022 онд 15 төсөл хэрэгжүүлэгч ирүүлсэн байна. Үйл ажиллагаа явуулаагүй төсөл хэрэгжүүлэгч нар тайлангаа ирүүлээгүй байна.

Аймгийн 2022-2026 онд хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөөг 2021 онд баталсан байна. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 2021 онд баталсан тул хууль тогтоомж бодлогын баримт бичигт нийцүүлж шинэчлэн баталсан гэж үзэх үндэсгүй байна.

Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд 2022-2026 онд хэрэгжүүлэх 14,886.1 сая төгрөгийн 75 арга хэмжээг төлөвлөж тусгасан боловч 2021, 2022 оны хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Аймгийн ойн сангийн нийт талбай 139.5 мянган га, үүний 72.8 хувийг буюу 101.7 мянган га нь ойгоор бүрхэгдсэн талбай эзлэх ба 27.2 хувийг ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлдэг. Алтай, Алтанцөгц, Баяннуур, Булган, Бугат, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумууд ойн нөөцтэй.

¹³ 4.1.23. "ангийн аж ахуй" гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30.3-т заасны дагуу агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах үйл ажиллагааг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу эрхэлдэг мэргэжлийн байгууллагыг;

Ойн нөөц бүхий сумууд “Ойн тухай хууль”-ийн 3.1.6¹⁴-д заасан ойн менежментийн төлөвлөгөөтэй байна. Ойн нөөц бүхий сумуудын Засаг дарга нар Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2¹⁵, 18.2.8¹⁶-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан байна.

Дээрх ойн нөөц бүхий 10 сум 2022-2026 онд хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөөгөө 2021 онд холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэж, аймгийн БОАЖГ-аар хянуулж, аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Ойн нөөц бүхий сумуудын 2022-2026 онд хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой сум бүр дунджаар 142.9-525.6 сая төгрөгийн 15-21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Сумууд ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Аймгийн Засаг дарга Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10¹⁷-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ой бүхий сумуудын 2022-2026 онд хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөөг баталж ажилласан боловч 2022 оны хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Ойн нөөц бүхий сумуудад ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нийт 32 нөхөрлөл байна. Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагууд Ойн тухай хуулийн 9.3¹⁸-д заасны дагуу ойн санг хэрхэн хамгаалж, зохистой ашиглаж байгаа, нөхөн сэргээх талаар ямар ажлууд хийгдсэн талаар мэдээлэл, судалгаа байхгүй байна.

Ойн нөхөрлөлүүд Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹⁹-д заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, менежментийн төлөвлөгөөгүй байна.

Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5-д зааснаар сумын ИТХ, сумын Засаг дарга нар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх бүрэн эрхтэй боловч хэрэгжүүлээгүй байна.

¹⁴3.1.6.“ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;.

¹⁵18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

¹⁶18.2.8.ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;

¹⁷17.2.10. ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;.

¹⁸9.3.Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

¹⁹21 дүгээр зүйл.Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг

21.1.Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна. /4.9.Засгийн газар хамгаалалтын бүсэд хамаарах эзэмшлийн ойн сангийн нэршлийн жагсаалтыг зориулалт, экологи, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг харгалзан тогтооно. 9.3.Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна./

Аймгийн Байгаль орчны газар нь Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3²⁰, 17.3.9²¹-д заасан ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10²²-т сумын Засаг даргын байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх эрхийг заасан.

Сумын Засаг дарга нь тухайн суманд нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах эрхтэй боловч ойн нөөц бүхий сумуудын Засаг дарга нар эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д "усны эх үүсвэр" гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг" гэж заасан тус аймаг тусгай хамгаалалтад авсан усны урсац бүрэлдэх эх газрын 491.88 мянган га талбайтай байна.

Хар ус-Ховд голын сав газрын нийт талбайн 47.2 хувийг тус аймгийн 12 сумын нутаг дэвсгэрийн 39409.4 хавтгай км талбай эзэлдэг байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн "Ус" үндэсний хөтөлбөр 2021 онд хэрэгжиж дууссан байна. Хөтөлбөрийн 2021 оны биелэлтийг тайлагнасан байна.

Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8. "Сав газрын менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан.

Хар ус-Ховд голын сав газрын менежментийн төлөвлөгөөтэй эсэх, хэрэгжилт ямар байгаа талаар шалгахад, менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа 2021 онд дууссан байна. Менежментийн төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийг тайлагнасан байна.

Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.3, 21.3.1, 21.3.2, 21.4, 21.4.1, 21.4.2, 21.4.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой ямар нэгэн арга хэмжээ тусгаагүй байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад аймгийн ан агнуурын болон ойн менежментийн төлөвлөгөөг хууль, тогтоомж бодлогын баримт бичигт нийцүүлж

²⁰ 17.3.Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

²¹ 17.3.9.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

²² 17.2.10²²-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд

шинэчлэн боловсруулж, батлуулах, БОАЖГ-ын даргад ойн нөөц бүхий сумуудын ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгөв.

A2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнээгүй байна

A.2.1 БОАЖ-ын сайдын Баян-Өлгий аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй, хүрэх түвшин хангагдаагүй байхад биелэлтийг өндөр үнэлгээгээр дүгнэсэн байна

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5²³, 27.5.10²⁴-д заасан төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1²⁵-д заасны дагуу БОАЖ-ийн сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгуулж ажилласан байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.8-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана” гэсний дагуу тусгасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээнд 9 зорилт, 57 арга хэмжээ тусгагдсан ба 44 арга хэмжээг 100 хувь, 5 арга хэмжээг 90 хувь 4 арга хэмжээг 70 хувь, 4 арга хэмжээг 30 хувь буюу ерөнхий дүнгээр 92.1 хувийн хэрэгжилттэй гэж аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан ба биелэлтийг 70 хувьтай гэж дүгнэжээ. Энэ нь бодит байдалтай нийцээгүй, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тусгаж төлөвлөөгүй, хүрсэн түвшнийг бодитой тайлагнаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилт, 2021 оны жилийн эцсийн тайланд хийсэн хяналт-шинжилгээний дүнгээр Баян-Өлгий аймагт хуулийн хэрэгжилт 0 хувьтай гарсан байхад аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 70 хувьтай дүгнэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд 7 зорилт, 49 арга хэмжээ тусгагдсан ба 37 арга

²³Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ,

²⁴27.5.10 байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийх,

²⁵Энэ хуулийн 14.1.6, 14.1.11-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж болно

хэмжээг 100 хувь, 6 арга хэмжээг 90 хувь, 6 арга хэмжээг 70 хувь буюу ерөнхий дүнгээр 95.1 хувийн хэрэгжилттэй гэж аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан ба биелэлтийг 100 хувьтай гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна. Хэрэгжилт хангалтгүй, хүрэх түвшин хангагдаагүй байхад биелэлтээр тооцсон байна. Тухайлбал:

Хамтран ажиллах гэрээнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрэх үр дүнд ангийн орлогоос 770.0 сая, ойн нөөцийн орлогоос 40.0 сая, ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 20.0 сая, газрын төлбөрөөс 320.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 120.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүйг харуулж байна.

БОАЖ-ын сайд 2023 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээг аймгийн Засаг даргын орлогчтой байгуулсан байна. Гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байна.

Гэрээний 9.1-д аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ гэрээний хэрэгжилтийг хагас /06 дугаар сарын 15-ны дотор/ болон бүтэн жилээр /12 дугаар сарын 01-ний дотор/ гаргаж хүргүүлэх талаар тусгасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх санхүүжилтийг дараах байдлаар тооцож холбогдох төсвийн захирагчид шилжүүлнэ” гэж заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газрын дансаар дамжуулж 2021 онд 66.7 сая төгрөг, 2022 онд 239.0 сая төгрөг баталж өгсөн байна.

Аймгийн Засаг даргын БОАЖ-ын сайдтай хийсэн гэрээний дагуу баталсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хөрөнгийг Байгаль орчин аялал, жуулчлалын газар зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 61.2²⁶, 61.3²⁷-т заасны дагуу аймаг, сумын Засаг дарга нар гэрээнд тусгагдсан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийн санхүүжилтийг тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 132 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 61.4²⁸-т заасны дагуу сумуудад 1061.9 сая төгрөгийг сум тус бүрээр баталсан байна.

²⁶ 61.2-т “Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар холбогдох шатны төсвөөс санхүүжүүлнэ.”

²⁷ 61.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.”

²⁸ 61.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална.”

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан журмын хэрэгжилтийг хангаж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгөв.

А2.2.Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнээгүй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5²⁹, 27.5.10³⁰, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1³¹-д заасны дагуу аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нартай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулан ажилласан байна.

Аймгийн Засаг дарга 2021, 2022 онд Толбо сумын Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулаагүй байна.

Сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд хугацааг 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулсан боловч 2021 оны гэрээг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр, 2022 оны гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байгуулжээ.

Сумдын Засаг дарга нартай 2021, 2022 онуудад байгуулсан гэрээний хавсралтад тусгасан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр арга хэмжээг төлөвлөхдөө тухайн сумын байгаль, экологийн онцлог байдлыг авч үзэж шалгуур үзүүлэлтүүдээ төлөвлөөгүй, хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний үзүүлэлт нь бүх сумуудад ижил байна.

Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т “Энэ хуулийн 39.1-д заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ” гэсэн боловч хагас жилээр гэрээг дүгнээгүй байна.

Гэрээний 1.2-т улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл, сумын Засаг даргын төлөөлөн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тусгасан гэсэн боловч энэ зарим арга хэмжээний хувьд шаардлага хангаагүй байна.

Хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг авч үзэхэд 2021 онд байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр 9, тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээр 4, нийт 13 арга хэмжээ, 2022 онд байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Сумуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээний 1.5-д “..... салбар бүрээс онцгой анхаарах асуудлуудыг хавсралтаар батлав” гэсэн боловч 2021 онд

²⁹27.5 Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ,

³⁰27.5.10 байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийх,

³¹40.1 Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ,

хавсралтаар баталсан хэрэгжүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтаар байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх 9 ажил, үйлчилгээг баталсан ба байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга 1 хэмжээ байна.

Сумуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээний 2022 оны хавсралтаар баталсан хэрэгжүүлэх ажил, үйлчилгээний жагсаалтаар байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх 4 ажил, үйлчилгээг баталсан ба үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга 1 хэмжээ байна.

Хүснэгт №8

Сум, тосгоны нэр	Гэрээ байгуулсан эсэх		Хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний чиглэл	Хэрэгжүүлэх ажил үйлчилгээний тоо	
	2021 он	2022 он		2021 он	2022 он
Алтай	Тийм	Тийм	Байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр	13	4
Алтанцөгц	Тийм	Тийм		13	4
Баяннуур	Тийм	Тийм		13	4
Бугат	Тийм	Тийм		13	4
Булган	Тийм	Тийм		13	4
Буянт	Тийм	Тийм		13	4
Дэлүүн	Тийм	Тийм		13	4
Ногооннуур	Тийм	Тийм		13	4
Сагсай	Тийм	Тийм		13	4
Толбо	Үгүй	Үгүй		0	0
Улаанхус	Тийм	Тийм		13	4
Өлгий	Тийм	Тийм		13	4
Цэнгэл	Тийм	Тийм		13	4
Цагааннуур тосгон	Тийм	Тийм		13	4

Эх сурвалж. Аудитын судалгаа

Аймгийн Засаг даргын сумуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээний үнэлгээ болон байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлсэн ажил үйлчилгээний гүйцэтгэлд ХШҮХ-ийн хийсэн үнэлгээ дараах байдалтай байна.

Хүснэгт: №9

Сум, тосгоны нэр	Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг дарга нарын байгуулсан гүйцэтгэлийн гэрээний							
	2021 он				2022 он			
	Дундаж үнэлгээ		Үүнээс : Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр		Дундаж үнэлгээ		Үүнээс : Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Алтай	146	91	9	79.0	116	86.7	4	80.0
Алтанцөгц	146	87.7	9	74.2	116	84	4	80.0
Баяннуур	146	0	9	0.0	116	78.1	4	47.5
Бугат	146	90	9	57.1	116	83.5	4	15.0
Булган	146	87	9	75.0	116	0	4	0.0
Буянт	146	90	9	76.0	116	85	4	50.0
Дэлүүн	146	91.8	9	75.0	116	80.3	4	85.0
Ногооннуур	146	90.8	9	62.0	116	88.1	4	50.0
Сагсай	146	90	9	90.0	116	85.8	4	60.0

Толбо	146	80	9	100.0	0	0	0	0.0
Улаанхус	146	85	9	88.0	116	83.5	4	100.0
Өлгий	146	90	9	90.0	116	84	4	85.0
Цэнгэл	146	80.4	9	69.0	116	81	4	97.5
Цагааннуур тосгон			9					
	146	81.05		71.9	116	70.6		57.69

Эх сурвалж. Аудитын судалгаа

Аймгийн БОАЖГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 86.4 хувийн биелэлттэй, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 98.1 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Аймгийн БОАЖГ-ын, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээ төлөвлөөгүй байна.

Аймгийн БОАЖГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээ төлөвлөсөн эсэхийг хянаж үзэхэд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг 100 хувь хангах,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг “Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заасан хугацаанд тогтмол оруулах” гэсэн 2 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад, харьяа төсөв захирагч болох сумын Засаг дарга нартай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээний хавсралтад байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээ оруулж, дүгнэж байх талаар зөвлөмж өгөв.

Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна

Б.1. Төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна

Б1.1. Байгалийн нөөцийг ашиглах төрөл, дээд хэмжээг зохих журмын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг аймгийн Засаг дарга БОАЖЯ-нд хүргүүлэх хугацааг тогтоосон заалт байхгүй байна.

Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасан.

Аймгийн БОАЖГ Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1³²-д заасны дагуу 2021-2023 онуудад аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар саналаа боловсруулж БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлсэн байна.

Ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал хүргүүлэх хугацааг Амьтны тухай хуульд 10 дугаар сарын 15-ны дотор, Засгийн газрын 2022 онд баталсан 02 дугаар тогтоолд 04 дүгээр сарын 01-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр хугацааг зөрүүтэй заасан байна.

Ангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1³³-гэж заасны дагуу БОАЖС-ын 2020 оны А/701, 2021 оны А/147 дугаар тушаалаар 2021 онд 18 угалз, 19 тэх, 4 халиун буга, 2000 загас, 2021 оны А/208 дугаар тушаалаар 2022 онд 15 угалз, 26 тэх, 5 халиун буга агнаж, 3500 загас барихаар тогтоосон байна.

Хүснэгт №10

/тоо, толгой/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он		Зөрүү	2022 он		Зөрүү	2023 он		Зөрүү
		Санал	Баталсан тоо		Санал	Баталсан тоо		Санал	Баталсан тоо	
Угалз	Толгой	24	18	6	25	15	10	31		31
Тэх	Толгой	28	19	9	28	26	2	41		41
Буга	Толгой	4	4	0	5	5	0	5		5
Зэрлэг гахай				0			0	10		10
Үйлдвэрлэлийн зориулалтаар барих загас	тонн	34	22	12	21.5	2,5	21.5	12.5	15	-2.5
Саарал чоно	Толгой			40	40	40	0	30	30	0
Шар үнэг	Толгой			50	50	50	0	60	30	30
Бусад загас	ш	4000	2000	2000	5000	3500	1500	4000	2000	2000

Эх сурвалж: Аймгийн БОАЖГазраас

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 2.3³⁴--т заасны дагуу дагуу аймгийн БОАЖГ 2023 онд тусгай зориулалтаар агнах, барих

³² 5.8.1 батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх”

³³ 26.1-д “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно”

³⁴ 2.3-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн

агнуурын амьтны тоо хэмжээний саналыг БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч тусгай зориулалтын агнах барих ан амьтны дээд хязгаар баталсан Сайдын тушаал одоо хүртэл гараагүй байна.

Амьтны тухай хуулийн 26.2³⁵-т заасны дагуу аймгийн ИТХурлын 2021 оны 22, 2022 оны 82, 2023 оны 135 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрээс ахуйн зориулалтаар агнах ан амьтан, барих загасны дээд хязгаарыг, 2021 оны 03, 2022 оны 63, 2023 оны 123 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрээс ойгоос бэлтгэх түлээний модны дээд хязгаарыг сум бүрээр тогтоосныг хэрэгжүүлж ажилласан байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 2.4-т "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно" гэсний дагуу 2023 оны хязгаарыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний дотор тогтоох ёстой боловч журамд заасан хугацаанаас хоцроож тогтоосон байна. Тухайлбал:

- Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 135 тоот тогтоолоор 2023 онд аймгийн нутаг дэвсгэрээс ахуйн зориулалтаар агнах ан амьтан, барих загасны дээд хязгаарыг баталсан.
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 123 тоот тогтоолоор 2023 онд аймгийн нутаг дэвсгэрээс ойгоос бэлтгэх түлээний модны дээд хязгаарыг баталсан.

Аудитын явцад гаргасан судалгаа Б.1.1-ийн дагуу үзэхэд тус аймагт агнуулах, барих зориулалтаар /Аргал, Янгир, Буга, Шар үнэг, Саарал чоно, Загас/ зургаан төрлийн ан амьтан, хэрэглээний мод, түлээний зориулалтаар /Шинэс, Улиас, Бургас, Хус/ дөрвөн төрлийн ой мод ашиглах дээд хэмжээг, Аргал, Янгир, Буга, үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих загасны нөөц тогтоосон ба шар үнэг, саарал чоно, ахуйн зориулалтаар агнах барих загас зэрэгт нөөц тогтоогоогүй байна.

Б1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журамд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна

Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 2.2³⁶-д БОАЖЯ-нд жил бүр 4 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлэхээр заасан боловч 2023 оны саналыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлээгүй, 2023 онд хүргүүлсэн байна.

БОАЖЯ-наас журмын 2.3³⁷-д заасан хугацааны дотор 2023 оны ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож ирүүлээгүй байна.

Засаг даргад хүргүүлнэ"

³⁵ 26.2"Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно", Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д "төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах,

³⁶ 2.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

³⁷ 2.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн ИТХ нь журмын 2.4³⁸-т заасан хугацаанд БОАЖЯ-аас ирүүлсэн хязгаарыг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоогоогүй байна. Тухайлбал: 2021 оны хязгаарыг 2020 онд, 2022 оны хязгаарыг 2021 онд, 2023 оны хязгаарыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний дотор тогтоох ёстой боловч хугацаа хоцроож тогтоосон байна.

Сумын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу журмын 2.5³⁹-д заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Аймгийн БОАЖГ 2023 оны орлогын төлөвлөгөөг БНАТ-3 маягтын дагуу сумуудаас санал авалгүй 2022 оны 08 дугаар сард аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө зөрүүтэй байгаа талаар сумуудаас гомдол гарч 11 дүгээр сард сумуудын саналыг авч нэгтгэн “Мэдээллийн сан”-д байршуулсан байна.

Мөн Аймгийн БОАЖГ 2023 оны орлогын төлөвлөгөөг БНАТ-5 маягтын дагуу сумуудаас санал авалгүй 2022 оны 08 дугаар сард аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Хүргүүлсэн орлогын төлөвлөгөө зөрүүтэй талаар сумуудаас гомдол гарсан тул 11 дүгээр сард сумуудаас санал авч нэгтгэж аймгийн Засаг даргад дахин хүргүүлсэн байна.

Аудитын дүнгээр аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын дарга, сумуудын Засаг дарга нарт Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх хэсгийн харилцааг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Б1.3.Байгалийн нөөцийн ус, рашаан ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгоогүй байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 2.2, 2.3-т заасны дагуу аймгийн ИТХ-аас тогтоосон тухайн онд ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг үндэслэн ан амьтан, ой зэрэг байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг олгодог байна. Аймгийн хэмжээнд 2021-2023 онд тус аймгийн 13 суманд ан амьтан, ой, ус рашаан ашиглах зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжуудад заасны дагуу олгосон байна.

Ан амьтан ашиглах зөвшөөрлийн талаар:

Аймгийн хэмжээнд 2021-2023 онд ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих 873, ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтан 150, гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтан 46, нийтдээ 1069 ашиглагчид 7724 ан амьтан агнах зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор ан амьтан агнах дээд хязгаарыг:

³⁸ 2.4.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

³⁹ 2.5.Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

- ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зориулалтаар 2021 онд 230 ашиглагчид 2000, 2022 онд 380 ашиглагчид 3400, 2023 онд 258 ашиглагчид 2065, нийтдээ 7465 ширхэг загас барих зөвшөөрөл,
- ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтан /саарал чоно, үнэг г.м/ 2022 онд 90, 2023 онд 60 ашиглагчид зөвшөөрөл,
- гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтан /угалз, тэх, буга, шонхор г.м/ 2021 онд 23 ашиглагчид 50, 2022 онд 23 ашиглагчид 59, нийт 109 ширхэг ан агнуулах зөвшөөрөл тус тус олгосон байна.

Гүйцэтгэлээр 2021 онд ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих 1440, 2022 онд 2157, нийтдээ 3597 ширхэг загас агнуулсан ба 2023 оны эхний хагас жилийн байдлаар хуульд заасан агнах зөвшөөрөл олгох хугацаа болоогүй байна.

Ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтан /саарал чоно, үнэг/ 2022 онд 90, 2023 онд 60 дээд хязгаар тогтоож ашиглах зөвшөөрөл гарснаас 2022 онд ашиглаагүй, 2023 онд 2 амьтан агнасан байна. Бусад амьтан агнах талаар 2021 онд батлаагүй байна.

БОАЖЯ-аас олгосон зөвшөөрлийн дагуу гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтан гүйцэтгэлээр 2021 онд 46, 2022 онд 51 байна.

Ой ашиглах зөвшөөрлийн талаар:

Тайлант онуудад ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэх зориулалтаар 2021 онд 1464 ашиглагчид 9566 м3, 2022 онд 1222 ашиглагчид 10770 м3, 2023 онд 119 ашиглагчид 9330 м3, нийтдээ 2805 ашиглагчид 29666 м3 ашиглах зөвшөөрөл гарснаас 2021 онд 5711.1 м3, 2022 онд 5509.7 м3, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 653 м3 мод ашигласан байна.

Сумуудын байгаль хамгаалагч нарын хэрэгжүүлсэн хяналтаар Алтанцөгц сумаас 9, Баяннуур сумаас 2, Бугат сумаас 1, Булган сумаас 1, Ногооннуур сумаас 2, Сагсай сумаас 3, Улаанхус сумаас 2, Цэнгэл сумаас 2, нийтдээ 22 ашиглагч зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн зөрчил илэрч холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан байна.

Ус, рашаан ашиглах зөвшөөрлийн талаар:

БОАЖГ-аас ирүүлсэн судалгаагаар хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар 2021-2023 онд ус ашиглах дүгнэлт гаргуулсан давхардсан тоогоор аймгийн 13 сумын 67 иргэн, аж ахуйн нэгжид 513029.8 шоо метр ус ашиглах зөвшөөрөл олгож, ашиглуулсан байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасны дагуу ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй давхардсан тоогоор 2021-2023 онд 13 сумын 378 иргэн, аж ахуйн нэгж ус ашигласан байна.

Алтанцөгц сумд 1, Сагсай сумд 1, Толбо сумд 2, Улаанхус сумд 2, Өлгий сумд 6, нийтдээ 12 аж ахуй нэгж аялал зугаалга, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашиглах зориулалтаар зөвшөөрөл авалгүй үйл ажиллагаа явуулж, ус ашигласан байна.

Дэлүүн, Цэнгэл суманд байрлах 2 сувилал Рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар 2021-2023 онд, Бугат сумын нутаг дэвсгэрээс рашаан ус савлаж зарах 1 үйлдвэр Рашаан-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ямар нэгэн зөвшөөрөлгүй 2022, 2023 онд рашаан усыг зөвшөөрөлгүй ашигласан байна.

Аудитын дүнгээр Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.1, 13.1.2, 13.1.5, 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.4, 18.1.5, 19.1.1, 19.1.3, 19.1.4 дэх заалтуудыг зөрчиж байгаа асуудалд аймгийн Засаг дарга, БОАЖГ-т албан шаардлага өгөв.

Б.1.4.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөлт, ногдуулалт хангалтгүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын нөөцийн төлбөрийн орлогоос бүрддэг байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2022 оны төлөвлөгөөг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 4.1-д “Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу сумуудын ИТХ-аас баталж, тайланг аймгийн БОАЖГ-т хүргүүлж ажилласан байна.


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2023 оны төлөвлөгөөг сумууд батлагдсан маягтын дагуу гаргаж 2022 оны 11 сард аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн боловч Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.5-д “Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Аймгийн БОАЖГ журамд заасны дагуу 2023 оны нийт орлогын төлөвлөгөөг нэгтгэж 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн Засаг дарга болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн боловч журмын 2.7-д Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан нийт орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ” гэсэн заалтыг мөн мөрдөөгүй байна.

Тус аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын нийт хэмжээг 2021 онд 975.5 сая, 2022 онд 1,319.6 сая, 2023 онд 2,115.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2021 онд 1,312.1 сая, 2022 онд 1,319.6 сая, 2023 оны эхний 5 сарын байдлаар 88.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

График: №01



Графикаас харахад орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр давуулан биелүүлсэн байна. 2021-2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, төвлөрүүлэлтийг нөөцийн төрлөөр задалж хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны төлөвлөгөө, төвлөрүүлэлтийн судалгаа хавсралт нэгээр харуулав.

Хүснэгт: №11

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Ургамал		Зөрүү	Газрын төлбөр		Зөрүү	Ус рашаан		Зөрүү	Ойн нөөц		Зөрүү	Ан амьтан		Зөрүү	Бүгд		Зөрүү
	Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн	
2021 он	-	-	-	247.5	179.8	(67.6)	20.0	14.8	(5.2)	31.0	34.5	3.6	677.0	1,083.0	405.9	975.5	1,312.1	336.6
2022 он	-	-	-	320.0	197.4	(122.6)	20.0	12.6	(7.4)	47.9	60.1	12.2	931.6	1,666.7	735.1	1,319.6	1,936.8	617.2
2023 он	-	-	-	305.7	78.0	(227.7)	25.0	0.8	(24.2)	65.0	3.8	(61.2)	1,719.7	5.6	(1,714.1)	2,115.4	88.2	(2,027.2)
ДҮН	-	-	-	873.2	455.3	(417.9)	65.0	28.2	(36.8)	143.9	98.4	(45.5)	3,328.3	2,755.2	(573.1)	4,410.4	3,337.0	(1,073.3)

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХУрлын тогтоол, сумуудын СТСангаас

Тус аймгийн 2021-2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, ногдуулалт, төвлөрүүлэлтийн байдлыг төлбөрийн орлогын нэр төрлөөр аюя үзвэл:

Аймгийн нутаг дэвсгэр дэх нэн ховор ургамал, ховор ургамал, элбэг ургамлын нөөц тогтоох ажил хийгдээгүй, ургамал түүх бэлтгэх, ашигладаг талаар судалгаа мэдээлэл байхгүй бөгөөд ургамал ашигласны төлбөрийн орлого төлөвлөгдөөгүй байна.

Тус аймгийн усны нөөцийн менежментийн төлөвлөгөө хийгдэж, усны нөөц тогтоогдоогүй байна.

Ус ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 20.0 сая, 2022 онд 20.0 сая, 2023 онд 25.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж 2021 онд 73.9 хувь буюу 14.8 сая, 2022 онд 63.1 хувь буюу 12.6 сая, 2023 оны эхний 5 сарын байдлаар 88.2 сая төгрөг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №12			/сая.төгрөгөөр/	
Үзүүлэлт	Ус рашаан		Зөрүү	хувь
	Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		
2021 он	20.0	14.8	5.2	73.9
2022 он	20.0	12.6	7.4	63.1
2023 он	25.0	0.8	24.2	3.2

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, СТС, Татварын албанаас

Аудитын явцад аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн судалгаа болон бусад холбогдох материалд үндэслэн шалгаж үзэхэд аялал зугаалгын зориулалтаар, хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар, рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар, цэвэр усны рашаан савлах зориулалтаар зэрэг төрлөөр нийтдээ 2021 онд 142, 2022 онд 151, 2023 онд 152 ус ашиглагч байгууллагын мэдээлэл байна.

2021 онд 142 ус ашиглагч байгууллагын 120 нь, 2022 онд 151 ус ашиглагч байгууллагын 120 нь, 2023 онд 152 ус ашиглагч байгууллагын 138 нь ус ашиглах зөвшөөрөлгүй, ус ашигласны дүгнэлт гаргуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.

Давхардсан тоогоор 2021 онд 22 ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж 185,038.5 шоо метр, 2022 онд 31 ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж 251,306.1 шоо метр, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 14 ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж 78,685.1 шоо метр ус ашиглахаар дүгнэлтээ гаргуулсан байна. Энэ нь аудитын явцад тогтоосон ус ашиглагч байгууллагуудын 15.5-20.5 хувийг эзэлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт гарч байна.

Дээрх тоон мэдээллүүдийг хүснэгтээр 2021-2023 оны байдлаар харуулав.

Хүснэгт №13																/тоо, хэмжээ/															
Нэр	Огноо	Аялал зугаалга зориулалтаар ашигласан						Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар						Рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар						Рашааны зориулалтаар						Бүгд					
		Ашиглагчийн			Зөвш-лтэй ашиглагч			Ашиглагчийн			Зөвш-лтэй ашиглагч			Ашиглагчийн			Зөвш-лтэй ашиглагч			Ашиглагчийн			Зөвш-лтэй ашиглагч			Ашиглагчийн			Зөвш-лтэй ашиглагч		
		тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ	тоо	үүнээс зөвшөөрөлтэй	Зөвш-лгүй	Зөвш-сөн хэмжээ		
Баян-Өлгий	2021 он	9	2	7	2782.5	131	20	111	182,256.0	2	0	2	0	0	0	0	0	142	22	120	185,038.5										
	2022 он	11	2	9	9360	137	29	108	241,946.1	2	0	2	0	1	0	1	0	151	31	120	251,306.1										
	2023 он	12	0	12	0	137	14	123	76,685.1	2	0	2	0	1	0	1	0	152	14	138	76,685.1										

Эх сурвалж: Аймгийн БОАЖГ-аас авсан судалгаа

Дээрх хүснэгтээс харахад аялал зугаалгын зориулалтаар 2021 онд 7, 2022 онд 9, 2023 онд 12, хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 2021 онд 111, 2022 онд 108, 2023 онд 123, рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалтаар 2021 онд 2, 2022 онд 2, 2023 онд 2 цэвэр усны рашаан савлах зориулалтаар 2022 онд 1, 2023 онд 1 ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж зөвшөөрөлгүй ус ашигласан байна.

Өөрөөр хэлбэл ус ашиглагч иргэн, ААНБ-ууд нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6, 28.3, 28.3.1, 28.3.2,

28.3.3, 28.4 дэх заалтыг зөрчиж ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулаагүй байна.

Аудитын явцад Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанаас 2021-2023 онд ус ашиглах дүгнэлт гаргасан байгууллагуудын судалгааг авч Татварын хэлтсийн ус ашиглагч байгууллагуудын төлсөн төлбөртэй тулгаж үзлээ.

Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанаас 2021 онд 8, 2022 онд 10, 2023 онд 2 ус ашиглагч байгууллагад Усны тухай хуулийн 28.4-т “Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчны алба тус тус гаргана” гэсэн заалтын дагуу дүгнэлт гаргасан байна.

Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанаас ирүүлсэн мэдээлэлд 2021 онд 8 ус ашиглагч 5.2 сая, 2022 онд 10 ус ашиглагч 5.8 сая төгрөг төлөхөөр төлбөр тогтоогдсон ба аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн мэдээлэлд 2021 онд 9 ус ашиглагчаас 11.0 сая, 2022 онд 9 ус ашиглагчаас 1.1 сая төгрөгийн төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу Сав газрын захиргаа болон аймгийн БОАЖГ-аас хэдэн байгууллагад дүгнэлт гаргасан, үүнээс хэд нь усны төлбөрөө гэрээний дагуу төлсөн, хэд нь төлөхгүй байгаа талаар тооцоо судалгаа гаргах боломжгүй байв.

Аудитын явцад зарим сумуудад ус ашиглалт, усны төлбөрийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Цэнгэл суманд байрлах “ЭС ЖИ ГРУПП” ХХК 2021, 2022 онд ус ашиглах дүгнэлт гаргуулж 2021 онд 19.9 сая, 2022 онд 34.2 сая төгрөг төлөхөөр ус ашиглах гэрээг байгуулсан байна. Гэтэл аймгийн татварын орлогын дансанд 2021 онд 4.0 сая, 2022 онд 4.0 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд 2021 онд 14.9 сая, 2022 онд 30.2 сая төгрөг гэрээний дүнгээс дутуу төлөгдсөн байна. Үүнийг тодруулж үзэхэд Цэнгэл сумын “Цагаан овоот уул” алтны уурхайн байгаль орчны мэргэжилтэн 2021-2022 онд тус тус 1 сар ажилласнаас дутуу төлөлттэй байгаа гэсэн тайлбар өгч байгаа боловч ажиллаагүй эсэхийг нотлох боломжгүй байна.

2022 оны гэрээнд ус ашигласны төлбөрт 34.2 сая төгрөг төлөхөөр тусгасан боловч БОАЖЯ-ны Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 557 тоот албан бичгээр тус сав газрын ажлын хэсэг Цэнгэл сумд ажиллах үеэр тус компанийг 1 сараас илүү ашиглалт явуулаагүй гэж орон нутгийн удирдлагуудын мэдээлснээр хоногт 300 м3 ус ашигласан гэж үзээд 2.8 сая төгрөгийн усны төлбөр төлөх, үүнээс илүү төлөх үндэслэлгүй гэж албан тоот ирүүлсэн байна. Гэтэл 2022 оны 6 сарын 30-ны өдөр аймгийн Татварын орлогын тоот дансанд 4.0 сая төгрөг тушаасан байна. Энэхүү компаний удирдлагууд Улаанбаатар хотод байдаг тул асууж тодруулах боломжгүй байна.

- Зарим сумуудад ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулагч байгууллага байгаа талаар ямар нэгэн судалгаа байхгүй, ус ашиглагч байгууллагуудыг журмын дагуу тогтоогоогүй байна. Энэ нь хуулийн 4.3-т “Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 31.0 сая, 2022 онд 47.9 сая, 2023 онд 65.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж 2021 онд 34.5 сая, 2022 онд 60.1 сая, 2023 оны эхний 5 сарын байдлаар 3.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 677.0 сая, 2022 онд 931.6 сая, 2023 онд 1,719.7 сая төгрөгөөр тус тус төлөвлөж 2021 онд 1,083.0 сая, 2022 онд 1,666.7 сая, 2023 оны эхний 5 сарын байдлаар 5.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №14

/тоо, хэмжээ/

Үзүүлэлт	Газрын төлбөр		Мдөс	Хувь
	Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		
2021 он	677.0	1083.0	-405.9	160.0
2022 он	931.6	1666.7	-735.1	178.9
2023 он	1719.7	5.6	1714.1	0.3

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХурлын тогтоол, сумуудын СТС, татварын албанаас

Аймгийн БОАЖГ-аас тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний 2023 саналыг хүргүүлсэн боловч тусгай зориулалтын агнах барих ан амьтны дээд хязгаар баталсан Сайдын тушаал одоо хүртэл гараагүй байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд 14 угалз, 16 тэх, 4 халиун буга, 12 шонхор, 2022 онд 14 угалз, 20 тэх, 4 халиун буга, 12 шонхор агнаж 2021 онд 1,110.2 сая, 2022 онд 1,664.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2021 онд 12 шонхорын үнэд 327.6, 2022 онд 13 шонхорын үнэд 409.3 сая төгрөг оруулсан байна. Шонхорын үнийг тухайн үеийн долларын ханшаар тооцож үзэхэд орлогыг үнэлгээний дагуу тооцож төвлөрүүлсэн байна.

Харин 2021, 2022 онд ангийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрсөн нийтдээ 2,774.8 сая төгрөгнөөс хоёр жилийн 24 шонхорын үнийг хасаж тооцоход үлдсэн 2,037.9 сая төгрөг нь бусад ан амьтаны орлогоос орсон байна.

Аудитын явцад 2021-2022 онд ан амьтан ангасан гурвалсан гэрээг бүх сумууд ирүүлээгүй тул гэрээ хэзээ хийгдсэн, хэдэн төгрөгийг хэдий хугацаанд төсөвт төвлөрүүлэх ёстойг тооцож тулгах, гүйлгээний утгыг тодорхой бичээгүйгээс ангийн орлогын дансны хуулгаас ан амьтан агнасны орлогыг ялган гаргах боломжгүй байна. Тухайлбал:

- Булган сумын агнуурын нөөцийн дансанд 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Мармара ХХК”-аас 2019 оны ангийн үлдэгдэл нэрийдлээр 4.8 сая төгрөг

орсон нь хэзээний гэрээгээр агнасан ангийн үлдэгдэл гэдгийг нотлох баримтгүй.

- Агнуурын нөөцийн орлогын дансны хуулгад орсон орлогын гүйлгээний утгад аль компаниас юуны мөнгө тушаасан талаар гүйлгээний утгад тодорхой бичигдээгүй тул Засгийн газрын 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан агнуулах амьтны жишиг үнэ, төлбөр хураамжийн хэмжээгээр тооцож дүнг тулгах боломжгүй байна. Булган сумын агнуурын нөөцийн төлбөрийн орлогын дэлгэрэнгүй дансны 2021 оны дансны хуулгад 6 дугаар сарын 28-наас 10 дугаар сарын 18-ны хүртэл 8 удаагийн гүйгээгээр нийт 136.2 сая төгрөгийн орлого орсон боловч аль компаниас ямар ангийн төлбөр орж байгаа нь тодорхой бус байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XI дүгээр хуралдааны 132 дугаар тогтоолоор газрын төлбөрийн орлогыг аймгийн хэмжээгээр нийтдээ 267.2 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд сумуудын баталсан газрын төлбөрийн төлөвлөгөө 305.7 сая төгрөг байна. Үүнийг тодоруулж үзэхэд Улаанхус сум 10.0 сая төгрөгөөр, Өлгий сум 28.5 сая төгрөгөөр газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн хэмжээнд газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 247.0 сая, 2022 онд 320.0 сая, 2023 онд 305.7 сая төгрөгөөр тус тус төлөвлөж 2021 онд 179.8 сая, 2022 онд 197.4 сая, 2023 оны эхний 5 сарын байдлаар 78.0 сая төгрөг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15

/тоо, хэмжээ/

Үзүүлэлт	Газрын төлбөр		Мөнгө	Хувь
	Төлөвлөгөө	Төвлөрүүлсэн		
2021 он	247.5	179.8	67.6	72.7
2022 он	320.0	197.4	122.6	61.7
2023 он	305.7	78.0	227.7	25.5

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-лын тогтоол, аймгийн ГХБХБГ, сумуудын СТС, татварын албанаас

Газрын төлбөрийн орлогын биелэлт 2021 онд 72.7 хувьтай, 2022 онд 61.7 хувьтай байгаа нь газрын төлбөрийн хураалт хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын явцад газрын цахим системээс 2021-2023 онд газар эзэмшигч, ААН, иргэний төлбөрийн ногдуулалт, төлөлтийг сум бүрээр шалгаж үзэхэд:

2021 онд 10354 иргэн, ААН-д газрын төлбөр ногдуулахаас 3835 иргэн, ААН-д 62.2 сая төгрөгийн татвар ногдуулж, 3920 газар эзэмшигч 163.6 сая төгрөг,

2022 онд 12314 иргэн, ААН-д газрын төлбөр ногдуулахаас 5882 иргэн, ААН-д 118.1 сая төгрөгийн татвар ногдуулж, 3127 газар эзэмшигч 140.6 сая төгрөг,

2023 онд 13652 иргэн, ААН-д газрын төлбөр төлөхөөр ногдуулахаас 8486 иргэн, ААН-д 462.4 сая төгрөгийн татвар ногдуулж, 683 газар эзэмшигч 27.7 сая төгрөгийг тус тус төлсөн байна.

Аймгийн ГХБХБГ-аас гаргасан 2021-2023 оны аймгийн хэмжээний ААН, иргэний газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн, ногдуулсан, төлсөн байдлыг графикаар харуулахад:

График:№02





График:№03



Эх сурвалж:Аймгийн ГХБХБГ-аас авсан судалгаа

Дээрх графикаас үзэхэд ААН, иргэний газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн болон ногдуулалт өссөн дүнтэй байгаа боловч газрын төлбөр төлсөн иргэн, ААН-ийн тоо буурсан байна.

Харин 2021, 2022 онд газрын төлбөрт төлсөн дүн нь ногдуулсан газрын төлбөрөөс их байгаа нь ногдуулалтыг цахим системд бүрэн оруулаагүй байсныг харуулж байна. Тухайлбал: Цэнгэл сум 2021 онд 91 иргэн ААН-д 75.6 сая төгрөг ногдуулснаас 147.1 сая төгрөг төлсөн байна.

Аймгийн ИТХ-аас баталсан газрын төлбөрийн төлөвлөгөө, аймгийн ГХБХБГ-ын цахим системд бүртгэсэн газрын төлбөрийн ногдуулалт зөрүүтэй байна

Хүснэгт №16

/тоо, хэмжээ/

Үзүүлэлт	Төлөвлөсөн		Төлсөн		Зөрүү	
	Аймгийн ИТХ-аас баталсан	Газрын цахим системд газрын төлбөр ногдуулсан	Газрын төлбөрийн орлогын данс	Газрын цахим системд орсон газрын төлбөр	Газрын төлбөрийн орлогын данс	Газрын цахим системд газрын төлбөр
2021 он	247.5	62.8	179.8	163.6	67.6	(100.8)
2022 он	320.0	118.1	197.4	140.6	122.6	(22.5)
2023 он	305.7	463.4	78.0	27.7	227.7	435.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-аас баталсан газрын төлөвлөгөөг газрын цахим системд бүртгэсэн газрын төлбөртэй тулгаж үзэхэд 2021 онд 67.6 сая, 2022 онд 122.6 сая төгрөгөөр зөрүүтэй, төсөвт төвлөрүүлсэн дүн 2021 онд 100.8 сая, 2022 онд 22.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Энэ нь нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын дүнгээр байгалийн нөөц ашигласны төлбөрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, ногдуулалтыг холбогдох хууль журмын дагуу үнэн

зөв хийж, төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж өгөв.

Б.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжээгүй байна

Б2.1. Төлбөрийн орлогыг 2021-2022 онд хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж батлуулаагүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021, 2022 онуудад “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1 -д заасан хувь хэмжээгээр төлөвлөж батлаагүй байна.

Аймгийн Засаг дарга Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журам”-ын 3.4 , 3.15-д заасны дагуу 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 132 тоот тогтоолоор Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁴⁰-т заасны дагуу 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар 1,058.2 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Сумын Засаг дарга нар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журам”-ын 3.16⁴¹-д заасны дагуу 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төсвийн төсөлд тусгаж сумын ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 2023 онд байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж баталсныг сумуудаар харуулахад:

Хүснэгт: №17		/хувиар/
№	Сумын нэр	2023 он
1	Алтай	121.1
2	Алтанцөгц	24.44

⁴⁰13.4-т “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

⁴¹3.16-д “Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.8, 3.11-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2 маягтын дагуу нэгтгэж, төсвийн төсөлд тусган жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”

3.4 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

3	Бугат	60.32
4	Баяннуур	11.74
5	Булган	106.72
6	Буянт	48.17
7	Дэлүүн	180.77
8	Ногооннуур	104.47
9	Сагсай	49.7
10	Толбо	61.87
11	Улаанхус	151.22
12	Цэнгэл	82.79
13	Цагааннуур	2.06
14	Өлгий	52.87
	Нийт	1058.24

Эх сурвалж. Аудитын судалгаа

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 2021-2023 онд байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж баталсныг аймгийн дүнгээр харуулахад:

Хүснэгт: №18

/сая төгрөгөөр/

Аймгийн нэр	Он	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө	Төлбөрийн орлогоос хуулийн дагуу зарцуулбал зохих дүн	Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний дагуу арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн дүн	Зөрүү
а	б	1	2	3	4=3-2
Баян-Өлгий аймаг	2021	852.5	390.5	0	-390.5
	2022	1319.6	561.6	0	-561.6
	2023	2115.37	969.7	1058.24	88.54

Эх сурвалж. Аудитын судалгаа

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2021, 2022 онуудад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хуулийн хувь хэмжээг батлаагүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. /Хүснэгт№../

Сумууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2023 онд зарцуулах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр 1,058.2 сая төгрөгөөр төлөвлөж баталсан боловч менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болон тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулах төлөвлөгөөг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.8⁴²-д заасны дагуу БНАТ-2А маягтаар төлөвлөөгүй байна.

Байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төлөвлөгөөг БНАТ-2А маягтаар төлөвлөсөн байдлыг мэдээллийн сангаас татаж үзэхэд дараах байдалтай байна.

⁴²3.8 “Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.6-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2-А маягтын дагуу боловсруулж, жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ”

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг ИТХ-аар 1,058.2 сая төгрөгөөр баталсан боловч, мэдээллийн санд төлөвлөгөөг 250.6 сая төгрөгөөр оруулж зарцуулах хөрөнгийн төлөвлөгөөг 807.6 сая төгрөгөөр дутуу оруулсан байна. Мэдээллийн санд зарцуулах хөрөнгийн төлөвлөлтийг үнэн зөв оруулаагүй байгаа нь журмын хэрэгжилтийг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Хүснэгт: №19

/сая төгрөгөөр/

ДД	Сумын нэр	Байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын...		
		Аймгийн ИТХ-аас 2023 онд баталсан төлөвлөгөө	БНАТ-2-А маягтаар зарцуулах зардлыг төлөвлөсөн байдал	Зөрүү
А	Б	1	2	3=1-2
1	Алтай	121.1	0	121.1
2	Алтанцөгц	24.44	16	8.44
3	Бугат	60.32	0	60.32
4	Баяннуур	11.74	0	11.74
5	Булган	106.72	14.9	91.82
6	Буянт	48.17	62.8	-14.63
7	Дэлүүн	180.77	68.8	111.97
8	Ногооннуур	104.47	35	69.47
9	Сагсай	49.7	34.3	15.4
10	Толбо	61.87	18.8	43.07
11	Улаанхус	151.22	0	151.22
12	Цэнгэл	82.79	0	82.79
13	Цагааннуур	2.06	0	2.06
14	Өлгий	52.87	0	52.87
	Нийт дүн	1058.24	250.6	807.64

Эх сурвалж. Мэдээллийн сан

Аудитын дүнгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, арга хэмжээний төлөвлөлтийг Мэдээллийн санд буруу оруулсан зөрчлийг арилгах, оруулаагүй байгаа сумууд нөхөж оруулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сумуудын Засаг дарга нарт зөвлөмж өгөв.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлтийг /БНАТ-2-А маягт/ оруулсан сумуудын мэдээллийн сангаас татаж харуулахад:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэсэг /БНАТ-2-А маягтын 1 дүгээр хэсэг/-ийг хавсралт хэсэгт харуулав.

Хүснэгт: №20

/сая төгрөгөөр/

Сумын нэр	Нөөц	Хэрэгжүүлэх арга хэжээ	Арга хэмжээг төлөвлөх үндэслэл			
			Менежментийн төлөвлөгөө	ИТХ-ын тогтоол	Төлөвлөсөн тоо хэмжээ	Нийт төсөвт өртөг, төгрөгөөр
Алтанцөгц	Ой	1	1	1	1	16.0
	1	1	1	1	1	16.0
Булган	Ан амьтан	5	0	1	32	12.4
	Газар	1	0	1	3	0.7
	Ой	1	0	1	307	1.8
	З	7	0	1	342	14.9
Буянт	Ан амьтан	12	9	0	321	61.0
	Газар	1	0	0	1	1.8

	2	13	9	0	322	62.8
Дэлүүн	Ан амьтан	2	0	1	2	35.0
	Газар	2	0	1	2	12.4
	Ой	2	0	1	2	21.4
	3	6	0	1	6	68.8
Өлгий	Газар	3	0	1	3	35.0
	1	3	0	1	3	35.0
Толбо	Ой	2	1	1	2	18.8
	1	2	1	1	2	18.8
Сагсай	Ан амьтан	4	0	0	9	32.6
	Газар	1	0	0	1	1.6
	2	5	0	0	10	34.3
Бүгд дүн	12	36	10	4	685	234.6

Эх сурвалж: Мэдээллийн сангаас

Алтанцөгц, Толбо сумууд менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөсөн.

Булган, Дэлүүн, Өлгий, Сагсай сумууд менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөсөн.

Буянт сум ан амьтны нөөцөд менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан, газрын нөөцөд менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөсөн байна.

Алтанцөгц, Баяннуур, Булган, Буянт, Дэлүүн, Өлгий, Толбо, Сагсай, Цэнгэл сумууд “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.8-д заасны дагуу БНАТ-2А маягтын 1 дүгээр хэсгийг, Алтанцөгц, Булган, Буянт, Дэлүүн, Өлгий, Толбо, Сагсай зэрэг сумууд 2 дугаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх хэсэг”-ийг тус тус боловсруулсан бол Цэнгэл сум 2-р хэсгийг боловсруулж оруулаагүй, Алтай, Бугат, Ногооннуур, Улаанхус сумууд БНАТ-2А маягтын 1 ба 2 дугаар хэсгийг төлөвлөөгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болон тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулах төлөвлөгөөг хүснэгтээр харуулав.

Хүснэгт: №21

/сая төгрөгөөр/

Аймгийн нэр	2023 он			Хувь [%]
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хуульд заасан хувь хэмжээгээр баталсан	Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болон тусгагдаагүй арга хэмжээнд зарцуулах төлөвлөгөө	Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээнд баталсан	
А	1	2	3=1-2	4=2/1
Баян-Өлгий аймаг	1,058.2	250.6	807.6	23.6%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Засгийг газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг

бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.8 дугаар заалтын хэрэгжилт 23.6 хувьтай байгаа нь хангалгүй үзүүлэлт байна.

Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй байна

Баян-Өлгий аймгийн байгалийн нөөц ашигласны 2021-2023 оны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, хуулийн хэрэгжилтийн хувь дараах байдалтай байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2021 оны төлөвлөгөө 852.5 сая, гүйцэтгэлээр төсөвт 1,312.1 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 459.6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2022 төлөвлөгөө 1,319.6 сая, гүйцэтгэлээр төсөвт 1,936.8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 617.2 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд хуульд зааснаар 2021 онд 600.0 сая төгрөг, 2022 онд 918.4 сая төгрөгөөс доошгүй хөрөнгийг зарцуулах ёстой боловч уг хөрөнгийг орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхэд зориулалт бус зарцуулсан байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.2⁴³, 3.3⁴⁴, 3.5⁴⁵, 3.6⁴⁶, 3.7⁴⁷ дахь заалтуудыг зөрчсөн зөрчлийг арилгах, хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор Байгаль орчны аялал жуулчны газрын төсөвт 2021 онд 66.6 сая төгрөг, 2022 онд 239.0 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргэх үйл ажиллагаанд зарцуулахаар баталсан ба 2021 онд 65.4 сая төгрөгийг, 2022 онд 171.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 3.11⁴⁸-д заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БНАТ-2-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн БОАЖГ-т хүргүүлэх ёстой боловч Алтай, Бугат, Баяннуур, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл сумууд хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн БОАЖГ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 3.12⁴⁹-т заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг

⁴³3.2-т "Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна",

⁴⁴3.3-д "Энэ журмын 3.1-д заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй тохиолдолд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг санхүүжүүлэхгүй

⁴⁵3.5-д Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ",

⁴⁶3.6-д Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр, энэ журмын 3.5.6, 3.5.7, 3.5.8-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ",

⁴⁷3.7-д "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно"

⁴⁸3.11 "Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ"

⁴⁹3.12-т "Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулна"

БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх арга хэмжээний зарцуулах төсвийг 1,061.9 сая төгрөгөөр баталсан. Сумын ИТХ-аас 2022 оны орлогын давсан хэсгээс 150.1 сая төгрөгийг нэмж 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх арга хэмжээний зарцуулах төсвийг 1,212.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн зарлагын 2023-2025 оны төлөвлөгөөний төсөл
2023.06.14 03:06:54 PM

Хүснэгт: №22

Сумын нэр	Арга хэмжээний нэр	Сумын ИТХ-аас 2022 оны давсан хэсгийг нэмж хуваарилсан байдал	Аймгийн ИТХ-аас баталсан	2022 оны давсан хэсэг
pro_name		2023 ИТХ батлагдсан	2023 ИТХ батлагдсан	Зөрүү
Алтай	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	147,130.0	120730	26,400.0
Алтанцөгц	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	24,075.0	24075	0.0
Баяннуур	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	11,370.0	11370	0.0
Бугат	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	59,955.0	59955	0.0
Булган	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	121,350.0	106350	15,000.0
Буянт	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	62,800.0	47800	15,000.0
Дэлгэн	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	249,200.0	180400	68,800.0
Ногооннуур	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	104,100.0	104100	0.0
Сагсай	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	52,480.0	49330	3,150.0
Толбо	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	61,500.0	61500	0.0
Улаанхус	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	172,650.0	150850	21,800.0
Цэнгэл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	82,425.0	82425	0.0
Өлгий төв сум	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	52,500.0	52500	0.0
Цагааннуур тосгон	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	1,750.0	1750	0.0
Баян-Өлгий аймаг шууд	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	8,750.0	8750	0.0
	Дүн	1,212,035.0	1061885	150,150.0

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ээс авсан судалгаа

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 2022 онд 617.2 сая төгрөгөөр давж биелэгдсэн бөгөөд сумууд 2023 онд байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх арга хэмжээнд давсан хэсгээс 150.1 сая төгрөгийг зарцуулахаар нэмж хуваарилсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, хуулийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт: №23

/сая төгрөгөөр/

Он	Байгалын нөөцийн төрөл, зарцуулах доод хязгаарын хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлбөрийн орлогыг хуулийн дагуу зарцуулбал зохих дүн	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан дүн	Хувь
2021	Ойн нөөц-85%	31.0	34.5	3.6	29.3	33.4	11
	Ан амьтны нөөц-50%	677.0	1,083.0	405.9	541.5	16.5	
	Газрын нөөц-15%	124.5	179.8	55.3	27.0	3.5	
	Усны нөөц-35%	20.0	14.8	(5.2)	2.2	12.0	
	Ургамлын нөөц-15%			-	-	-	
	Дүн	852.5	1,312.1	459.6	600.0	65.4	
2022	Ойн нөөц-85%	47.9	60.1	12.2	51.1	127.4	19
	Ан амьтны нөөц-50%	931.6	1,666.7	735.1	833.4	27.0	
	Газрын нөөц-15%	320.0	197.4	(122.6)	29.6	8.0	
	Усны нөөц-35%	20.0	12.6	(7.4)	4.4	9.0	
	Ургамлын нөөц-15%	-	-	-	-		
	Дүн	1,319.6	1,936.8	617.2	918.4	171.41	
2023	Ойн нөөц-85%	65.0	3.8	(61.2)	3.2		0
	Ан амьтны нөөц-50%	1,719.7	5.6	(1,714.1)	2.8		
	Газрын нөөц-15%	305.7	70.9	(234.8)	10.6		
	Усны нөөц-35%	25.0	0.8	(24.2)	0.3		
	Ургамлын нөөц-15%	-	-	-	-		
	Дүн	2,115.4	81.0	(2,034.3)	16.9		

Эх сурвалж: Аудитын судалгаа

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилт 2021 онд 11 хувь, 2022 онд 19 хувийн хэрэгжилттэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2023 онд зарцуулах төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Дэлүүн сум байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/32 тоот захирамжаар 7-р багийн Байз голын засварт 600.0 мянга, хүүхдийн паркийн модон хашааны засварын ажилд 380.0 мянга, золбин нохой устгах зардалд 953.0 мянга, нийт 1,933.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.
- Дэлүүн сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/49 дүгээр захирамжаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас нохой устгахад 2,964,200 төгрөгийг зориулалт бус зарцуулж, сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/66 дугаар захирамжаар А/49 дүгээр захирамжийг хүчингүй болгож, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлж, буцаан төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч хэрэгжүүлээгүй байна.
- Сагсай сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/38 тоот захирамжаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас сумын төвийн золбин нохой устгах зардалд 1,065.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2023 оны зарцуулалт.

Хүснэгт №24

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	2023		
		Зориулалтын дагуу	Зориулалт бус	Нийт дүн
1	Алтай	0	0	0
2	Алтанцөгц	6.82	0	6.82
3	Бугат	0.15	0	0.15
4	Баяннуур	1.2	0	1.2
5	Булган	8.35	0	8.35
6	Буянт	14.67	0	14.67
7	Дэлүүн	19.92	4.89	24.81
8	Ногооннуур	16.69	0	16.69
9	Сагсай	0	1.06	1.06
10	Толбо	0	0	0
11	Улаанхус	21.72	0	21.72
12	Цэнгэл	2.25	0	2.25
14	Өлгий	0	0	0
	Нийт	91.77	5.95	97.72

Эх сурвалж: Аудитын судалгаа

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зориулалт бус зарцуулсан нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7⁵⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Дэлүүн, Сагсай сумуудын Засаг дарга нарт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу зарцуулах, зориулалт бус зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авч ажиллаагүй байна

В.1. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчгүй, хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв байдал хангагдаагүй байна.

В.1.1 Мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал 2022 оноос хангагдсан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ”, 35 дугаар зүйлийн 35.1.17-д “1.Улсын мэдээллийн сан дараах зүйлийн талаарх мэдээллээс бүрдэнэ. 17/байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал” гэж заасан.

⁵⁰ 3.7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”

Байгаль орчин аялал жуулчлалын яам болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж буй “ВИОФИН-II” төслөөр Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын”-ын хүрээнд боловсруулан www.eic.mn/finance/ мэдээллийн санг 2022 оноос нэвтрүүлсэн байна.


Мэдээллийн санд 2022 оны 07 дугаар сараас аймаг, сумуудын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээлэл, төлөвлөгөө, гүйцэтгэлийг журамд заасан маягтын дагуу мэдээлж эхэлсэн байна.

Тус мэдээллийн сан бий болсноор хойш аймаг, сумууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, давсан орлогын зарцуулалтыг Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын”-ын дагуу нарийвчлан гаргаж, гүйцэтгэлийг Байгаль орчин аялал жуулчлалын яамд тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавих боломж, нөхцөл бүрдсэн байна.

Мэдээллийн сан нь журамд заасан бүх мэдээллийг багтаасан бөгөөд мэдээлэл оруулах заавар болон схемийн хэлбэрээр оруулах хялбар аргаар мэдээллийг оруулах бүрэн боломжтой байна.

Үүнд: Төлөвлөгөө талыг оруулах заавар, маягт

График:№04



Гүйцэтгэл талыг гаргах заавар, маягт

График: №05



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга “ВИОФИН-II” төслийн сургагч багш нар мэдээллийн сангийн талаар 3 удаа цахимаар сургалт зохион байгуулсан байна.

Тус мэдээллийн сантай холбоотой шинэчлэлт, сайжруулалт хийгдэж байгаа ба 2023 оны 7 дугаар сараас эхлэн шинэ хувилбар хэрэгжиж эхлэхээр болсон байна.

Мэдээллийн санд сумууд 2022 онд мэдээллээ зөв оруулсан эсэхийг шалгаж үзэхэд:

- 2022 онд Алтанцөгц, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл зэрэг 9 сум,
- 2023 онд Алтанцөгц, Булган, Толбо зэрэг 3 сум мэдээллийн санд мэдээллийг зөрүүтэй оруулсан байна.

2023 оны 6 дугаар сарын байдлаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын төлөвлөгөөг мэдээллийн санд оруулсан байдал нь аймгийн хэмжээнд 95.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.”, 4.4-т “Энэ хуулийн 4.3-т заасан мэдээлэлд иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, ашиглах хугацаа, хэмжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг шаардлагатай үзүүлэлтийг тусгана” гэсэн заалтын хэрэгжилт 2021-2022 онуудад хангалтгүй байсан ба мэдээллийн санд оруулдаг болсноор 2023 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтын 1.2-д “Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад энэ журмын хавсралт маягтуудыг (цаашид “БНАТ маягт” гэх) ашиглах бөгөөд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна” гэснийг 2023 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 4.6-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ” гэсэн боловч аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2022, 2023 онд санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийгдээгүй байна.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг

бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.9-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан өдөр тутмын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд түгээнэ”,

4.10-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн орлогын хэсгийг бүрдүүлэх, төлөвлөх, зарцуулах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангана”,

4.11-т “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрдүүлнэ” гэж заасан. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь дээрх журмын заалтуудыг хэрэгжүүлж www.nature.bo.gov.mn вэб сайт болон аймгийн БОАЖГ-ын facebook хуудаст мэдээ, мэдээллээ тогтмол ил тод байршуулж, иргэд, олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангаж ажилласан байна.

В.1.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо үр дүнгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 -т “Сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 10 хоногийн дотор зохих шатны татварын албанд гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ” гэж заасан.

Аудитын явцад аймгийн Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал, жуулчлалын газруудаас авсан судалгаа, тоон мэдээллүүд зөрүүтэй байгаа нь нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Тухайлбал: Газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтийг шалгахад Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар газрын төлбөрийн программд оруулсан ногдуулалт, төлөлтийн дүн аймгийн Татварын хэлтсийн татварын ногдуулалт, төлөлтийн дүнгээс зөрүүтэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн орлогыг зохистой төлөвлөж орон нутгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахад төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж өгөв.

В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнээгүй байна

В.2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын 2018-2021 оны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийсэн байна

Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.7-д “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ХШҮДА-ын газраас “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын”-ын 2018-2021 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, дотоод аудит хийсэн байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээг дараах чиглэлээр хийнэ”, 50.1.2-т “хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох” гэж заасныг хэрэгжүүлж “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дахь хэсэгт заасан ан, амьтан, ус, ургамал, ойн нөөц болон газрын нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын мэдээ, тайланд хяналт- шинжилгээ хийж, зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээг дараах чиглэлээр хийнэ”, 50.1.1-д “хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшнийг тодорхойлох” гэсний дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2018-2021 оны түвшнийг тодорхойлж, дүгнэлт өгч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгсөн байна.

Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж ой, ан амьтан, газар, ургамал зэрэг байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай холбоотой зөрчлүүдийг илрүүлж ажилласан байна. Тухайлбал:

- 2021 онд 28 зөрчил илрүүлэн түүнээс 25 зөрчлийг арилгуулсан ба ойн нөөцтэй холбоотой 2 зөрчил арилгаагүй байна.
- 2022 онд 17 зөрчил илрүүлэн түүнээс 17 зөрчлийг бүрэн арилгуулсан байна. Графикаар харуулбал:

График: №06



Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн БОАЖГ-ын 2021-2022 оны үйл ажиллагааны тайлан

Байгаль орчны газраас хийсэн хяналт шалгалтаар 2021 онд 14 аж ахуйн нэгж, 5 байгууллагаа, 699 иргэнд 16.8 сая төгрөгийн, 2022 онд 85 аж ахуйн нэгж, 141 байгууллагаа, 733 иргэнд 1.1 сая төгрөгийн төлбөр тогтоож, барагдуулсан байна.

График: №06



Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн БОАЖГ-ын 2021-2022 оны үйл ажиллагааны тайлан

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар сумуудын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дагаврыг тооцож ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт сумуудын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгөв.

В.2.2 Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагаас 2021-2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгдээгүй байна

Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2021, 2022, 2023 онуудад Байгалийн нөөц ашигласны талаар ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй болохыг 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 02/211 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “...Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох”, “...Нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах...”, “...Засаг даргын өргөн мэдүүлснээр тухай аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах”

бүрэн эрхийн хүрээнд байгалийн нөөцийн төлбөрийн орлогыг бүрдүүлэх харилцаанд оролцох зохицуулалттай.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "...төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална ..." гэснийг хэрэгжүүлээгүй ба байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос орох төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээний дагуу байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн 2021, 2022 оны төлөвлөгөөг батлаагүй байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйл "Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх", Ойн тухай хуулийн 17 дугаар зүйл "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх", 18 дугаар зүйл "Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх", Газрын тухай хуулийн 20 дугаар зүйл "Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрх", Усны тухай хуулийн 11 дүгээр зүйл "Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх", Байгалийн ургамлын тухай хуулийн 8 дугаар зүйл 2-т Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтоож, хэрэгжилтийг хянана" гэж заасан хяналт хэрэгжүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумын ИТХ-д Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон холбогдох журамд заасан хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

Аудитын хугацааны турш сумуудын байгаль орчны хяналтын улсын байцаагчид аудитад ирүүлэх шаардлагатай судалгааг 6 дугаар сарын 10-нд гаргаж ирүүлсэн боловч тоон мэдээллүүд нь зөрүүтэй байв.

Булган, Цэнгэл, Бугат сумын БОУХБ нар судалгаа гаргаж ирүүлээгүй, аудитын ажилд саад учруулсан, дуудахад ирээгүй, холбогдох материалуудыг ирүүлээгүй тул аймгийн БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч аудитын судалгааг гаргаж ажилласан.

Аудитын дүнгээр Булган, Бугат, Цэнгэл сумуудын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

ХАВСРАЛТ: №01

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2023 оны төлөвлөгөө, төвлөрүүлэлтийн судалгаа

№	Үзүүлэлт	БОАЖСайдын тушаалаар тусгай зориулалтаар агнахаар тогтоосон ангийн тоо хэмжээ								Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор ахуйн зориулалтаар агнах, барих загасны тоо хэмжээний дээд хязгаар							
		2021 онд /БОАЖСайдын 2020 оны А/701-р тушаалаар/				2021 онд /БОАЖСайдын 2021 оны А/147-р тушаалаар/		2022 онд /БОАЖСайдын 2021 оны А/208-р тушаалаар/		2021 он /аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 22-р тогтоол/	2022 онд /аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 82-р тогтоол/				2023 онд /аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 135-р тогтоол/		
		Угалз	Тэх	Буга	Загас	Угалз		Угалз	Тэх		Халиун Буга	Загас	Загас	Саарал чоно	шар үнэг	Загас	Саарал чоно
1	Алтай сум	3	1					3	2		100	150	4	5	150	2	3
2	Алтанцөгц сум	2	2						2		100	150	4	4	100	3	3
3	Баяннуур сум		1						2		300	150	3	4	100	3	2
4	Бугат сум	1	2					1	2		100	150	3	4	100	2	3
5	Булган сум	1	3	2		2		2	2	2	100	150	3	4	100	2	0
6	Буянт сум	2						1			100	150	3	4	100	2	2
7	Дэлүүн сум	3	1					3	2	1	300	1,000	4	4	500	3	3
8	Ногооннуур сум	1	5					2	10		100	150	4	4	100	3	3
9	Сарсай сум										100	150	3	5	100	3	3
10	Толбо сум	1	2					1	2		400	1,000	3	4	500	2	2
11	Улаанхус сум	2	2					2	2		100	150	3	4	100	2	3
12	Цэнгэл сум			2						2	200	150	3	4	100	3	3
	ДҮН	16	19	4	2,000	2		15	26	5	2,000	3,500	40	50	2,050	30	30

ХАВСРАЛТ: №02

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэсэг

Сумын нэр	Зарцуулах хөрөнгийн нэр	Байгалийн ургамал	Ан амьтан	Газар	Ой	Ус, рашаан	Нийт
	А	1	2	3	4	5	6
Алтанцөгц	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	30.75	31.50	2.00	0	64.25
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	14.30	0	1.70	0	16.00
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-46.50%	(%)	-85.00%	(%)	-73.39%
Баяннуур	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	10.20	32.46	1.19	0	43.85
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	5.10	5.25	1.02	0	11.37
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-50.00%	-16.17%	-85.30%	(%)	-103.50%
Булган	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	199.23	22.20	3.78	0	225.21
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	12.45	0.70	1.85	0	15.00
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-6.25%	-3.15%	-48.83%	(%)	-14.13%
Буянт	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	99.60	12.00	0	0	111.60
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	61.00	1.80	0	0	62.80
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-61.24%	-15.00%	(%)	(%)	-121.71%
Дэлүүн	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	346.80	32.50	0	0	379.30

	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	56.40	12.40	0	0	68.80
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-16.26%	-38.15%	(%)	(%)	-38.59%
Өлгий	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	0	125.00	0	0	125.00
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	0	18.75	0	0	18.75
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	(%)	-15.00%	(%)	(%)	-100.00%
Толбо	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	102.00	42.50	0	0	144.50
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	18.83	0	0	0	18.83
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-18.46%	(%)	(%)	(%)	-32.82%
Сагсай	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	81.60	11.00	1.80	0	94.40
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	32.64	1.65	0	0	34.29
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-40.00%	-15.00%	(%)	(%)	-77.97%
Цэнгэл	Төвлөрүүлэх төлбөрийн орлого, төгрөгөөр	0	92.44	70.50	26.22	0	189.17
	БОХНСАХ-ний зардалд, төгрөгөөр	0	46.24	14.00	22.18	0	82.42
	БНАТТХ-ийн 18.1-д заасан хувиар /а/	(%)	-50.02%	-19.86%	-84.59%	(%)	-104.22%

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох зарим хууль тогтоомж, эрх зүйн акттай нийцээгүй байна.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт хангалтгүй байна.
3. Аймгийн ан агнуурын болон ойн менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт нийцүүлэн шинэчлэн батлаагүй байна.
4. БОАЖС-дын Баян-Өлгий аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй, хүрэх түвшин хангагдаагүй байхад биелэлтийг өндөр үнэлгээгээр дүгнэсэн байна
5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжээгүй байна.
6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөвлөлт, ногдуулалт хангалтгүй байна
7. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй байна
8. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчгүй, хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв байдал хангагдаагүй байна.
9. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо үр дүнгүй байна.
10. Бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагаас 2021-2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгдээгүй байна

САНАЛ:

Үндэсний аудитын газар-т: Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах.Үүнд:

1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох зарим хууль тогтоомж, эрх зүйн акттай нийцээгүй байгаа өөрчлөх санал хүргүүлэх.

Байгаль орчин аялал жуулчлалын яам-д:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Баян-Өлгий аймагт 2021-2022 онд угалз, тэх, халиун буга агнуулах талаар БОАЖЯ, сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээнүүдийг аудитын явцад үзүүлээгүй тул угалз, тэх, халиун буга агнуулснаас орох орлого бүрэн төвлөрсөн эсэхийг нотолж чадаагүй тул холбогдох байгууллагуудад асуудал тавьж шалгуулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ИТХ-ын дарга Ш.Хабыл-д:

1.Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх хэсгийн 2.4-д заасныг хэрэгжүүлж ажиллах;

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж ажиллах;

II. Аймгийн Засаг дарга А.Камелият-д:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар

2. Аймгийн ан агнуурын болон ойн менежментийн төлөвлөгөөг хууль, тогтоомж бодлогын баримт бичигт нийцүүлж шинэчлэн боловсруулж, батлуулах;

3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан журмын хэрэгжилтийг хангаж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлэх;

4. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар сумын Засаг дарга нартай байгуулах гэрээний хавсралтад байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээ тусгуулж, дүгнэж байх;

5. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх хэсгийн 2.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, ногдуулалтыг холбогдох хууль журмын дагуу үнэн зөв хийж, төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлж ажиллах;

7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн орлогыг зохистой төлөвлөж орон нутгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахад төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллах;

III. Сумын ИТХ-ын дарга нарт-д:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

IV. Сумын Засаг дарга нарт-д:

1. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх хэсгийн 2.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, арга хэмжээний төлөвлөлтийг Мэдээллийн санд буруу оруулсан зөрчлийг арилгаж, оруулаагүй байгаа сумууд нөхөж оруулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

V. Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Ш.Марат-д

1. Ойн нөөц бүхий сумуудын ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

2. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх хэсгийн 2.6, 2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах

3. Сумуудын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум,

Утас/факс: (976) 7042 2667

2023. 06. 20 № 226

төний -ны № -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА М.ХУАНГАН ТАНАА

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилтийн тайланд нэмэх саналгүй
болно.

ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Ш.МАРАТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/12

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, сумын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН